

Бага боловсролын I-V ангийн сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, жагсаалт шаардлага

1.1. Бага боловсролын Монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, жагсаалт, шаардлага

Монгол хэлний сургалтын зарим хэрэглэгдэхүүний тайлбар, анхаарах зүйл

Бага боловсролын монгол хэлний сургалтад хэрэглэх хэрэглэгдэхүүний нэр төрлийг тодруулан, ялган ангилахдаа сургалтын хөтөлбөрийн агуулгатай уялдуулахаас гадна суралцахуйн удирдамжийг судлан, анги бүрийн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог зэргийг харгалзан боловсруулсан болно. Хэрэглэгдэхүүний шаардлагыг нийтлэг болон тусгай хэмээн зааглан үзсэн билээ. Анги ахих тусам хэрэглэх, агуулгын залгамж холбоотой хэрэглэх хэрэглэгдэхүүнүүдийн нийтлэг шаардлагыг тодруулахаас гадна нэмэлт шаардлагыг анги бүр дэх хөтөлбөрийн агуулгыг баримжаалан томъёоллоо.

Монгол хэлний хичээлийн онцлог нь хүүхдийн унших, бичих, сонсох, ярих, хэл зүйг хэрэглэх чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ эх хэлээрээ санаа бодлоо бичгээр болон амаар ойлгомжтой, цэгцтэй илэрхийлэх, бусадтай үр дүнтэй харилцдаг иргэн төлөвшүүлэх үндсэн зорилготой юм. Харилцах, илэрхийлэх хэрэгцээнд тулгуурладаг учраас аман зохиол, уран зохиолын болоод уран зохиолын бус эх бичвэрүүдийг сургалтын чухал тулгуур хэрэглэгдэхүүн гэж үзнэ. Унших эх зохиол, бичвэрүүдийн агуулга, үгийн тоо хэмжээ, агуулгын тохирц зэрэг нь анги бүрд өөр өөр байх боловч эхэд тавих ерөнхий шаардлагыг судлан, эх сонгож авах, үнэлгээний даалгавар боловсруулахад харгалзан үзэхийг зөвлөж байна.

Ном товхимлын хувьд зөв бичгийн дүрмийн журамласан толь, үгийн утгын тайлбар толь, эх зохиолын эмхэтгэлийг тодорхой шалгуурын дагуу сонгон авсан бөгөөд одоогоор бага ангийн сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохирсон уран сайхны эх зохиол, ялангуяа уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх, танин мэдэхүй, хүмүүжлийн ач холбогдолтой эх зохиол одоогоор тун ховор байна. Ялангуяа 1-3 дугаар ангийн сурагчдад уншуулах 40-150 хүртэлх үгийн нөөцтэй, сонирхолтой үйл явдалтай, шаардлага хангасан бичвэртэй зохиол олдоц муу байна. Гэсэн хэдий ч монгол хэлний сургалтын хөтөлбөрт буй өгүүллэг, үлгэр зохиох зорилготой суралцахуйн зорилтын хүрээнд багш нар болон багш нарын шууд чиглүүлгийн дор сурагчид зохион бичиж байгаа туршлага бий болж байна. Үүнтэй холбоотойгоор монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүнд “Дуурайн зохион бичих жишээ загвар бичвэрүүд” гэсэн нэр төрлийг оруулсан болно. Анги бүрд ямар эх зохион бичихийг монгол хэлний сургалтын хөтөлбөрт тусгасан билээ. Бага ангийн сурагчдын хувьд өөрөө шууд зохиох гэхээсээ илүү уншсан эхийн утга, бүтэц, үг хэллэг, дүрслэлт үг, өвөрмөц үг, баатруудын үйл хөдлөл, баатруудын гадаад дүр байдал, орчны дүрслэл, зохиолчийн санаа гэх мэтийг дуурайх аргаар зохиож сурах нь үр дүнтэй байдаг. Иймээс жишээ загвар болохуйц зохиосон эхийн сантай байх нь багшийн хувьд чухал юм. Багш өөрөө эх зохиохын зэрэгцээ сурагчдаар зохиолгосон тодорхой шалгуур хангасан эхийг хичээлийн хэрэглэгдэхүүнд тооцон хэрэглэж болно.

Бага ангийн сурагчид монгол хэлний сургалтаар үгийн нөөцтэй болох нь хамгийн чухал зорилтуудын нэг юм. Уншсан зохиолоос шинэ үгийн мэдлэгтэй болохоос гадна өөрийн санаа бодлыг тусган зохион найруулж бичихдээ мэдэж сурсан үг болон танил бус үг хэрэглэж бичих нь насан туршийн боловсролыг дэмжих нэг арга зам болдог. Иймээс монгол хэлний хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний нэг төрөлд танил бус үг бүхий “Үгийн сангийн багц карт” хэмээх хэвлэмэл бүтээгдэхүүнийг онцолж байна. Ямар эх

зохиож бичихээс шалтгаалж багш бүр үгийн нөөцийг бэлдэн, сурагчдад санал болгох нь тэдний суралцахуйг дэмжих бодит дэмжлэг болно.

Аман зохиол, уран зохиолын, уран зохиолын бус эхийг сонгохдоо тухайн ангид боловсруулагдсан нэмэлт шаардлагаас гадна хүснэгтийн дээд хэсэгт буй эхийн агуулга болон бичвэрт тавигдах нийтлэг шаардлагыг давхар судлахыг зөвлөж байна.

Хүснэгт 1. Бага боловсролын монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүний товчоо (нэр, төрлөөр)

№	Хэрэглэгдэхүүний төрөл		Нийтлэг хэрэглэгдэхүүн	Анги тус бүрийн хэрэглэгдэхүүний тоо				
				I анги	II анги	III анги	IV анги	V анги
1	Хэвлэмэл бүтээгдэхүүн	Ном товхимол	6	-	-	-	-	-
		Зурагт үзүүлэн	1	4	2	2	2	2
		Бичвэр үзүүлэн /хэвлэмэл хуудас	9	2	4	6	6	7
		Цомог	1	0	0	0	0	1
2	Дижитал үзүүлэн /сонсох, харах/		3	4	1	0	0	0
	Нийт		32	10	7	8	8	10

Монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүний шаардлага

Монгол хэлний хичээлийн онцлог нь хүүхдийн унших, бичих, сонсох, ярих, хэл зүйг хэрэглэх чадварыг хөгжүүлэн, үндэсний соёл сэтгэлгээний онцлогийг ойлгож эх хэлээрээ бахархах мэдлэг, чадвар, хандлагатай болгодог учраас уран зохиолын болоод уран зохиолын бус эх бичвэрүүдийг сургалтын чухал тулгуур хэрэглэгдэхүүн гэж үзнэ. Унших эх зохиолын төрөл зүйлийн онцлог, үгийн тоо хэмжээ, агуулгын тохирц зэрэг нь анги бүрд өөр өөр байх боловч эхэд тавих ерөнхий шаардлагыг энэ хэсэгт тодруулан авч үзлээ.

Эх зохиолын агуулгад тавих нийтлэг шаардлага:

- Суралцагчийн нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн үе шатанд тохирсон байна. (ажиглалт, анхаарал, ой тогтоолт, сэтгэхүй, хэл ярианы хөгжил)
- Уран зохиолын болон уран зохиолын бус эхийн агуулга нь шинжлэх ухааны үндэслэлтэй, алдаагүй байна.
- Үндэсний түүх, соёл, уламжлал, үнэт зүйлийг тусгасан байна.
- Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн байна.
- Монгол уламжлал, ёс заншлыг дээдлэхийг илэрхийлсэн агуулгатай байна.
- Эх орон, эцэг, эх, ах дүүс, нутаг, уул ус, байгалиа хайрлах агуулгатай байна.
- Монгол хэл, бичиг, соёлоо дээдлэн хамгаалах, бахархах хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн байна.
- Бусдыг хайрлах, хүндэтгэх, бусдаар бахархах, өөртөө итгэлтэй болох, өөрийгөө ойлгох, мэдрэх чадварыг хөгжүүлэх сургамжит агуулгатай байна.
- Тунгаан бодон сэтгэж, үзэл бодлоо баримттай, нээлттэй илэрхийлэхэд чиглэсэн байна.
- Сэтгэл хөдлөлөө мэдэрч, хянаж, түүнийгээ зөвөөр илэрхийлсэн байна.
- Гэр бүл, найз нөхдийн орчин дахь харилцааны зөв, эерэг байдлыг харуулсан байна.
- Гэр бүлдээ болон өөртөө тохирсон хөдөлмөр эрхлэх, бусдад туслах, бусдаас суралцах агуулгатай байна.
- Хамтарч суралцахын ач тусыг харуулсан, багшаа хүндлэх, бусдыг хүндлэх агуулгатай байна.

- Сайхан, муухай, гайхамшгийн тухай тусгасан, гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлэх агуулгатай байна.
- Дэлхийн хүүхдийн сайн зан үйл, сайхан үйлс хэргээс суралцах боломжтой байна.
- Байгаль, нийгмийн үзэгдлийг танин мэдэх үүрэг бүхий сонирхолтой агуулгыг оруулсан байна.
- Юмнаар юм хийх бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх, сэдэлжүүлэх агуулга бүхий байна.

Эх зохиолын бичвэрт тавих нийтлэг шаардлага:

- Бага ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон, хоёрдмол утгагүй, бодит утгыг илэрхийлсэн үг хэллэгтэй байна.
- Сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлж, хэл ярианы чадварыг хөгжүүлэхүйц монгол үгийн баялаг сонголттой байна.
- Ойлгомжтой найруулгатай, найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагүй байна.
- Унших арга барилд суралцаж байгаа 1,2 дугаар ангид гол төлөв богино өгүүлбэрээс бүтсэн, харьцангуй шууд утгатай, богино хэмжээний хялбар эх байх бол анги ахих тусам эх дэх үгийн тоо ихэсч, утга агуулга нь гүнзгийрч, өгүүлбэрийн бүтэц нь нийлмэл байна.
- Хэт нуршуу биш сонирхолтой адал явдалтай, хүмүүжлийн болон танин мэдэхүйн хувьд зөв нөлөөлөлтэй, зохисгүй үг хэллэггүй байна.
- Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлын элементүүд, сөрөг үг хэллэг, утга санааг агуулаагүй байна.

Зурагт үзүүлэнд тавих нийтлэг шаардлага:

- Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавигдах ерөнхий шаардлага /Зурагт хуудас/ MNS 5553-3:2005, 5553-4:2005 стандарт, Хэвлэлийн бүтээгдэхүүний чанарт тавих шаардлага MNS 6789:2019 стандартын дагуу хийгдэнэ.
- Зурагт хуудасны зориулалт, хэрэглээнээс хамаарч хэмжээг тодорхойлно. Хэрэв хананд байрлуулах бол хүүхдэд харагдах байдлыг тооцохыг анхаарна.
- Нэг талдаа хэвлэлттэй, удаан хэрэглэх зориулалттай бүтээгдэхүүнийг зузаан болгож болно.
- Хананд байршуулах зурагт үзүүлэн нь өнгө үзэмжтэй, удаан хэрэглэгдэх бат бөх материалаар хийсэн, хүүхэд бүрд тод харагдахуйц, цэвэр, гаргацтай бичсэн байх, үсгийн хэмжээ тохиромжтой, өлгөхөд зориулсан хэмжээ, даацтай байна.
- Анги танхимд ил байрлуулах зурагт хуудасны хэвлэлд хэрэглэх материалууд нь байгаль, цаг уурын нөлөөлөлд тэсвэртэй, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байна. Зурагт хуудасны зориулалт болон хаана байрлуулахаас хамаарч гадуур нь бүрж болно.
- Хэвлэх зурагт үзүүлэн нь гар хуруу зүсэхгүй материалаар удаан хэрэглэхээр хийсэн, аюулгүй байдлыг хангасан байна.
- Фото зураг, уран зураг нь өнгөний ялгаралтай, тусгал, нягтрал сайтай байхаас гадна эх сурвалж болон фото зургийг авсан хүний нэрийг дурдсан байна.
- Багц хэлбэрээр байгаа хуудсан бүтээгдэхүүнд агуулгын жагсаалт гаргасан байна. Агуулгын жагсаалтыг багцны хавтсан дээр эсвэл хавчуурга хуудсан дээр хэвлэнэ. Багцыг хавтас, дугтуй, хайрцагт савлана.

Дижитал үзүүлэнд тавих нийтлэг шаардлага:

- Уншигч, өгүүлэгч, тайлбарлагчийн яриа нь тод чанга, ойлгомжтой, дуу, дүрсний шаардлагыг хангасан цахим үзүүлэн байна.

*Хүснэгт 2. Бага боловсролын монгол хэлний нийтлэг хэрэглэх сургалтын
хэрэглэгдэхүүний жагсаалт, шаардлага, тоо хэмжээ*

№	Хэрэглэгдэх үүний нэр	Анги	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага /хэмжээ, холбогдох стандарт, бусад/	Тоо хэмжээ	
I. ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН					
Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавих ерөнхий шаардлага. /Ном, товхимол/ MNS 5553-1:2005/, стандартыг баримтална. Харин агуулга, арга зүйг боловсруулахдаа “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS 5418:2008 стандарт, хэвлэлийн бүтээгдэхүүний чанарт тавих шаардлага MNS 6789:2019 стандартын дагуу хийгдэнэ.					
Ном, товхимол					
1	Зөв бичих дүрмийн журамласан толь	I-V	Монгол хэлний зөв бичгийн дүрмийн журамласан толь	МУ-ын Хэлний бодлогын зөвлөлөөр батлагдсан, хэл шинжлэлийн эрдэмтдийн оролцоотой бүтээгдсэн, нийтээрээ дагаж мөрдөж байгаа, 30000 үгээс дээш үгийн нөөцтэй байна.	Багш бүрд 1
2	Хэлц үгийн тайлбар толь бичиг	I-V	"Монгол хэлц үгийн тайлбар толь"	Монгол ахуй амьдрал, соёлтой холбоотой хэлц үгийн сонголттой, хэлцийн утгыг илэрхийлсэн зурган зүүлттэй, тайлбартай толь бичиг байна.	Ангийн номын санд
3	Үгийн тайлбар толь бичиг	I-V	Сурагчийн монгол хэлний тайлбар толь (Бага анги), МУИС, Монгол судлалын хүрээлэн,	“Монгол хүүхдийн үгийн сангийн чадамж, нөөцийг тодорхойлох нь” суурь судалгаан дээр үндэслэж бүтээгдсэн, хэвлэгдсэн байна.	Ангийн номын санд
4	Монголын хүүхдийн шилдэг зохиолын түүвэр, эмхэтгэл	I-V	“Монголын хүүхдийн уран зохиолын дээж” I боть	Хүүхдийн зохиолч, судлаач Г.Ловор, хүүхдийн зохиолч Д.Гармаа нарын эмхэтгэн хэвлүүлсэн ном байна.	Ангийн номын санд
5	Дэлхийн хүүхдийн шилдэг зохиолын түүвэр, эмхэтгэл	I-V	<p>–“Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж” I боть Ж.Дашдондог эмхэтгэсэн</p> <p>“Дэлхийн хүүхдийн яруу найргийн дээж” Ж.Дашдондог эмхэтгэсэн,</p>	Хүүхдийн зохиолыг судалдаг эрдэмтдээр хянан тохиолдуулсан, хүүхдийн зохиолчдын бүтээлийн дээжийг эмхэтгэсэн, утга агуулга, бичлэгийн хувьд шаардлага хангасан бүтээл байна.	Ангийн номын санд

6	Монгол ардын аман зохиолын эмхэтгэл	I-V	-“Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг”	Монгол улсын Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргасан, аман зохиол судлаач, академич Д.Цэрэнсодном, эрдэмтэн судлаач Ш.Гаадамба нарын эмхэтгэл байна.	Ангийн номын санд
<p>Зурагт үзүүлэн /зурагтай болон бичвэртэй/ Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавих ерөнхий шаардлага. Зурагт хуудас/ MNS 5553-3:2005, 5553-4:2005 стандартыг баримтална. Харин агуулга, арга зүйг боловсруулахдаа “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS 5418:2008 стандарт, хэвлэлийн бүтээгдэхүүний чанарт тавих шаардлага MNS 6789:2019 стандартын дагуу хийгдэнэ.</p>					
1	Зурагт үзүүлэн (багц)	I-III	<p>Сэдэвт болон цуврал зурагт үзүүлэн нь дараах агуулга бүхий байна.</p> <ul style="list-style-type: none"> -Жилийн 4 улирал, -Байгалийн үзэгдэл, -Хүнсний ногоо, жимс жимсгэний ач холбогдол, хэрхэн хэрэглэх -Хот хөдөөгийн амьдралын онцлог, -Ан амьтдын үр төл, хооллолт, амьдралын орчин, -Ажил мэргэжлийн талаар ШУ, техник технологийн хөгжлийг харуулсан сэдэвт зураг -Адал явдалтай, сонирхолтой үйл явдал бүхий зураг 	<p>Хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон, зөв харьцаатай, бодит фото болон зураачийн зурсан зураг байна.</p> <ul style="list-style-type: none"> Оюуны өмчийн зөрчилгүй байна. -Сонирхолтой, хүмүүжлийн болон танин мэдэхүйн ач холбогдол бүхий үйл явдалтай сэдэвт зургууд А2 хэмжээнээс багагүй байна. -Цуврал зургууд А3 хэмжээнээс багагүй байна. Утгын хувьд өгүүлбэр, эх зохиоход тохиромжтой байна. 	Ангид 1 багц
2	Зөв бичих дүрмийн бичвэрт багц үзүүлэн	I-V	Тухайн ангид судлах дүрмийн тодорхойлолт, дүрмийн зүй тогтлыг харуулсан бүдүүвч үзүүлэн байна.	Анги хооронд залгамж холбоотой, удаан хэрэглэхэд бат бөх, А2 хэмжээнээс багагүй байна.	Ангид 1 багц
3	Зохион бичих чадварыг дэмжих үзүүлэн	II-V	<p>Найруулгын 5 шалгуурыг загварчлан бичсэн үзүүлэн</p> <p>-Бичсэн эх нь уншихад ойлгомжтой байна уу?</p>	Өнгө үзэмжтэй, удаан хэрэглэгдэх бат бөх материалаар хийсэн, хүүхэд бүрт тод харагдахуйц, цэвэр, гаргацтай бичсэн байх, үсгийн хэмжээ тохиромжтой, өлгөхөд зориулсан хэмжээ,	Ангид 1 ширхэг

			<ul style="list-style-type: none"> -Үг, өгүүлбэр нэммээр байна уу? -Үг, өгүүлбэр хасмаар байна уу? -Үгийн байрлалыг солих уу? -Үгийг солих уу? 	даацтай байх, А2 хэмжээнээс багагүй байна.	
4	Найруулан бичих чадварыг дэмжих үзүүлэн	II-V	Зохион бичих арга барилыг загварчлан үзүүлсэн үзүүлэн А.Н.Д-ын арга буюу А- анхлан бодох [төлөвлөх], Н- ноороглон бичих Д- дахин сайжруулж бичих	Өнгө үзэмжтэй, удаан хэрэглэгдэх бат бөх материалаар хийсэн, хүүхэд бүрт тод харагдахуйц, цэвэр, гаргацтай бичсэн байх, үсгийн хэмжээ тохиромжтой, өлгөхөд зориулсан хэмжээ, даацтай байх, А-2 хэмжээнээс багагүй байна.	Ангид ширхэг 1
5	Эхийн бүтцийн бүдүүвч схем харуулсан үзүүлэн	II-V	<ul style="list-style-type: none"> -Мэндчилгээ -Талархал -Болсон явдал -Захидал (Талархсан, бахархсан, бусдын үзэл бодлыг дэмжсэн, дэмжээгүй утгатай) -Төлөвлөгөө -Урилга -Уриалга -Танилцуулга [гэр бүлийн, номын] -Үлгэр, -Өгүүллэг зэрэг эх тус бүрийн бүтцийг харуулсан бүдүүвч 	Агуулгын хүрээнд бичихэд дэмжлэг болохуйц, эхийн эхлэл, гол, төгсгөл гэсэн бүтцийг зураглан бүдүүвчилсэн схем нь А2 хэмжээнээс багагүй байна.	Ангид багц 1
6	Ардын аман зохиолын эхийн сан /багц хэвлэмэл хуудас/	I-V	<ul style="list-style-type: none"> -Онъсого, таавар -Бэлгэ дэмбэрлийн үг -Зугаа үг -Ертөнцийн гурав -Зүйр цэцэн үг -Хэлц үг -Хэл зүгшрүүлэх үг -Түргэн хэллэг -Жороо үг -Шүлэг -Магтаал -Ерөөл -Монгол ардын үлгэр, домог 	Ардын аман зохиолуудаас сонголт хийхдээ хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон бичлэг найруулгатай, өргөн зөв утга агуулгатай, зарим хэлц үгийн тайлбартай, зөв бичгийн дүрмээр бичигдсэн, монгол ахуйн сэтгэлгээний үг хэллэгтэй болохыг анхаарна.	Ангид багц 1

			-Дэлхийн сонгодог үлгэр, -Ёгт үлгэр		
7	Уран зохиолын болон уран зохиолын бус эхийн сан /багц хэвлэмэл хуудас/	I-V	-Монгол ёс, соёл өв уламжлал, үнэт зүйлстэй холбоотой эхүүд -Олон соёлын холбоотой эхүүд -Нийгэмшихүйн чадварыг дэмжихтэй холбоотой эхүүд -Танин мэдэх, сэтгэн бодох чадварыг дэмжихтэй холбоотой эхүүд -Эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй холбоотой эхүүд -Байгаль орчны үзэгдлийн тухай эхүүд -Бие бялдрын чадварыг дэмжсэн танин мэдэхүйн эхүүд -Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шингээсэн эхүүд -Ургамал, ан амьтны тухай танин мэдэхүйн эхүүд -Үйл явдал бүхий эхүүд	Тухайн ангийн суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хүмүүжлийн болон танин мэдэхүйн хувьд зөв нөлөөлөлтэй, зохисгүй үг хэллэггүй, сургамжтай, сонирхолтой адал явдалтай байх. Үйл явдал бүхий уран зохиолын эхүүд нь эхлэл, өрнөл, төгсгөл хэсэгтэй ба эхлэл хэсэг нь үйл явдал өрнөх орчин, баатар, нөхцөл байдлыг танилцуулсан, өрнөл хэсэг нь гэнэтийн, сонирхолтой үйл явдлаас бүтсэн, төгсгөл хэсэг нь гол хэсгийнхээ асуудлыг шийдвэрлэсэн байна. Анги ахих тутам зохиолын үйл явдлын орчныг дүрсэлсэн, баатруудын харилцан яриатай эхүүдийг сонгон уншина. Зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй гоо зүйн хэм хэмжээ, шаардлага хангасан байна. I анги 80-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн эх байна. II анги 150-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн эх. Зарим зохиол нь хэлц үгийн сонголттой байна. III анги 200-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн болон нийлмэл бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн эх байна. Зарим зохиол нь хэлц үгийн сонголттой байна. IV анги 250-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн болон	Сурагч бүрд 1 багц

				нийлмэл бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн эх V анги 300-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн болон нийлмэл, холимог бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн эх байна. Гадаад үг орсон, зарим зохиол нь хэлц үгийн сонголттой байна.	
8	Үгийн сангийн багц карт /хэвлэмэл хуудас/	I-V	-“Ямар” гэсэн асуултад хариулагдах өнгө зүс, хэлбэр дүрс, овор хэмжээ, шинж байдлыг заасан тэмдэг нэрийн нөөц, цуглуулга -Үйл, үг, хэлц үг, эсрэг болон ойролцоо утгатай үгсийн нөөц, цуглуулга	Эх, өгүүлбэр зохион найруулан бичихэд зориулагдсан, сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, монгол ахуй, сэтгэлгээ, соёлын онцлогийг тусгасан үгийн нөөцтэй байна.	Сурагч бүрд 1 багц
9	Үнэлгээний карт	I-V	1. Зөв, хурдан, ойлгож унших чадварыг үнэлэх эх болон асуултууд 2. Бичих чадварыг үнэлэх карт	1. Блумын асуултад хариулж бичих хэсэгтэй, зөв, эсвэл буруу хариулсныг тэмдэглэх зай бүхий талбартай А4-А5 хэмжээтэй карт байна. Минутадад уншсан үгийн тоо болон зөв уншаагүй авиа, үгийг тэмдэглэх зай бүхий карт байна. Бичих чадварыг үнэлэх картад тавих шаардлага нь: Ойлгомжтой бичсэн эсэх, найруулгын алдаа гаргаагүй эсэхийг тэмдэглэх зайтай байна. Алдсан үгийн тоо болон ямар дүрмийн алдаа гаргасан эсэхээ тэмдэглэх зайтай байна. Эхийн бүтцийн дагуу утгыг оновчтой гаргасан эсэхийг тэмдэглэх зайтай байна.	Сурагч бүрд 1
<p>Цомог Цомгийн форматын хэмжээг Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавих ерөнхий шаардлага MNS 5553-6:2005-ын 5.1.1 дугаар заалтыг дүгээр заалтыг баримтлан сонгоно. Фото зургийг дүрслэхдээ JPEG-ийг хэрэглэх, зураг, график зэргийг дүрслэхдээ PNG 1.0-ийг хэрэглэх вектор зургийг дүрслэхдээ SVG 1.1 болон SVG 1.2 Tiny стандартуудыг хэрэглэх, зургийн нягтрал нь 2000 pixels-ээс багагүй хэмжээтэй байна.</p>					

1	Эх зохиох, илтгэл тавихад хэрэглэх зураг	III-V	Бодит зүйлийн фото болон уран зураг, гэрэл зураг	Интернет болон бусад эх сурвалжаас авсан, илтгэх, ярих, хэлэлцэх, шүүн тунгаах агуулгатай үнэн зөв мэдээлэл бүхий зураг байна.	Ангид 1 багц
<p>Дижитал үзүүлэн /сонсох, харах ... (видео, аудио хэрэглэгдэхүүн) БШУ-ы сайдын 2021 оны А/193 дугаартай тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентод тавих шаардлага”-ыг баримтална.</p>					
1	Сонсох аудио эхүүд	I-V	<ul style="list-style-type: none"> -Ан амьтны тухай танин мэдэхүйн эхүүд -Байгаль орчны үзэгдлийн тухай эхүүд -Нийгэмшихүйн чадварыг дэмжихтэй холбоотой эхүүд -Танин мэдэх, сэтгэн бодох чадварыг дэмжихтэй холбоотой эхүүд -Бие бялдрын чадварыг дэмжсэн танин мэдэхүйн эхүүд -Эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй холбоотой эхүүд -Монгол ёс, өв уламжлалтай холбоотой эхүүд 	<p>Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хүмүүжлийн болон танин мэдэхүйн хувьд зөв нөлөөлөлтэй, зохисгүй үг хэллэггүй, сургамжтай, сонирхолтой адал явдалтай байна.</p> <p>Үйл явдал бүхий уран зохиолын эхүүд нь эхлэл, өрнөл, төгсгөл хэсэгтэй ба эхлэл хэсэг нь үйл явдал өрнөх орчин, баатар, нөхцөл байдлыг танилцуулсан, өрнөл хэсэг нь гэнэтийн, сонирхолтой үйл явдлаас бүтсэн, төгсгөл хэсэг нь гол хэсгийнхээ асуудлыг шийдвэрлэсэн байна.</p> <p>Анги ахих тутам зохиолын үйл явдлын орчныг дүрсэлсэн, баатруудын харилцан яриатай эхүүдийг сонгон уншина.</p> <p>Зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй гоо зүйн хэм хэмжээ, шаардлага хангасан байна.</p>	Анги бүрд 1 багц
2	Үгийн утгын тайлбар бүхий интерактив бичлэг	II -V	Монгол хэлц үг, ертөнцийн гурав, зүйр цэцэн үг зэргийн утгыг тайлбарлаж харуулсан зурагтай цахим хэрэглэгдэхүүн	Тайлбарлагчийн яриа нь тод, оновчтой утгыг харуулсан зурагтай, дуу, дүрсний шаардлагыг хангасан цахим үзүүлэн байна.	ЗАН бүрд 1 багц
3	Зөв бичих дүрмийн сорил бүхий	II -V	Блумын бүх түвшинд боловсруулсан сорил даалгаврын хувилбар байна	liveworksheet, kahoot, wordwall зэрэг цахим программ ашигласан ажлын хуудас, дасгал даалгавар байна.	Анги бүрд 1 багц

	интерактив даалгавар		Хөдөлгөөнт тоглоомын арга зүйн шийдэлтэй, сурагчдад тунгаах бодох, эргэцүүлэх боломжийг олгосон, хариу нь дүрмийн тайлбартай хамт байрласан зохиомжтой байна.	
		Өгүүлбэрүүд	Асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх асуусан, хүүрнэсэн, анхааруулах утгатай өгүүлбэрүүд байна.	Анги бүрд 1 багц

Хүснэгт 3. Монгол хэл (I анги)-ний сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, шаардлага, тоо хэмжээ

№	Хэрэглэгдэх үүний нэр	Хэрэглэгдэхүүний агуулга	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага /хэмжээ, холбогдох стандарт, бусад/	Тоо хэмжээ
Зурагт үзүүлэн				
1	Цагаан толгойн үсгийн үзүүлэн	Цагаан толгойн 35 үсгийн том жижиг дармал үсэг таниулах зурагт үзүүлэн	Цагаан толгойн том жижиг дармал үсэг нь тухайн үсгийг таниулж байгаа үгийн утгыг харуулсан зурагт үзүүлэн байна. Үсгийн бичлэг хэлбэр, хүүхдэд тод харагдахуйц, өнгө нь тохиромжтой байна. Цагаан толгойн үсгийн эхлэл төгсгөлийн зурлагыг дэвтрийн шугамаар баримжаалан дарааллыг дугаарлан харуулсан өнгөөр ялгасан, тод том бичвэртэй АЗ хэмжээнээс багагүй байна.	Анги бүрд 1 багц
		Цагаан толгойн 35 үсгийн зурлагатай том, жижиг бичмэл үсгийн зурлагын үзүүлэн		Анги бүрд 1 багц
2	Үеийн хүснэгт	1 дүгээр шатны 8 гийгүүлэгч, 2 дугаар шатны 8 гийгүүлэгчийн задгай ба битүү үеийн хүснэгтүүд	Үсгийн хэмжээ нь хүүхэд бүрт тод харагдахуйц, үеийг зөв бичсэн байна.	Анги бүрд 1 багц
3	Зохиомол болон зохиомол бус үгт карт, зурагт-үгт карт	Цагаан толгойн үсгийг нүдлэх үед тохирсон бодит зүйлийн 1-2 үетэй үгийн зураг бүхий картууд	Үсгийн хэмжээ хүүхэд бүрд тод харагдахуйц, үеийг зөв тасалсан, нэг талд нь зураг, нөгөө талд нь зургийн нэр байна. Зохиомол үг нь зөвхөн нэг авиаг өөрчлөх замаар үүснэ. Жишээ нь: нар, наг	Анги бүрд 1 багц
4	Хэрчмэл үсгийн сан	Үсгээ нүдлэх, үг бүтээхэд хэрэглэх хэрчмэл үгүүд	Агуулгын хувьд жишээ нь үсэг бүр 5 аас доошгүй байна.	Сурагч бүрд 1 багц
	Уран зохиолын ба уран	-Монгол ёс, өв уламжлал, ахуй	15-60 хүртэлх үгтэй, үеийг өнгөөр ялгасан, уншихад хялбар, танил, танил биш үгийн нөөцтэй, олон гийгүүлэгч	

5	<p>зохиолын бус эхийн сан /багц хэвлэмэл хуудас/</p>	<p>соёлтой холбоотой эхүүд -Танин мэдэх, сэтгэн бодох чадварыг дэмжихтэй холбоотой эхүүд -Эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй холбоотой эхүүд -Ан амьтны тухай танин мэдэхүйн тухай богино хэмжээтэй хялбар эх -Сонирхолтой үйл явдал бүхий эхүүд -Зөв унших чадвар болон ойлгох тоочих, төсөөлөх чадваруудыг дэмжсэн агуулгатай байна.</p>	<p>нэг доор давхцаагүй үгтэй, 3 үетэй үг цөөн орсон, энгийн өгүүлбэрээс бүтсэн богино хэмжээтэй хялбар эхүүд байна. А5 хэмжээнээс багагүй, үсгийн фонд 16 поинтоос багагүй байна. I ангид унших эхийн нийт үгийн 80-аас доошгүй хувь нь танил үгийн нөөцтэй, хураангуй, дэлгэрэнгүй энгийн өгүүлбэрээс бүтсэн эх байна. - Сургамжит, хүмүүжлийн ач холбогдолтой эхүүд байна.</p>	<p>Сурагч бүрд 1 багц</p>
6	<p>Ардын аман зохиолын эхийн сан</p>	<p>Сурагчдын ойлгох, тоочих, төсөөлөх чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна. -Онъсого -Бэлгэ дэмбэрлийн үг -Зүйр цэцэн үг -Хэл зүгшрүүлэх үг -Түргэн хэллэг -Монгол ардын үлгэр -Дэлхийн сонгодог үлгэр зэрэг эхүүд байна.</p>	<p>А5-А6 хэмжээтэй, тарааж өгөх зориулалттай байна. I анги 80-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн өгүүлбэрээс бүтсэн үлгэр -Энгийн үг хэллэгтэй 2 мөртөөс бүтсэн зүйр цэцэн үг, -2-4 мөр бүхий хэл зүгшрүүлэх үг, түргэн хэллэг, бэлгэ дэмбэрлийн үг - Од гараг эрхэс, амьтан ургамал, байгалийн үзэгдэл, хүний бүтээсэн зүйл гэх мэтийг өнгө, тоо, дүрс, онцлог шинжээр нь адилтган далдалсан агуулгатай 2-4 мөр бүхий онъсого байна.</p>	<p>Сурагч бүрд 1 багц</p>
<p>Дижитал үзүүлэн</p>				
1	<p>Авианы дуудлага бүхий видео бичлэг</p>	<p>Цагаан толгойн үсэг, үсгийн авиаг хэрхэн зөв дуудах дуудлага</p>	<p>Зөв, тод дуудсан дуу, дүрсний шаардлага хангасан видео бичлэг байна.</p>	<p>Анги бүрд 1 багц</p>
2	<p>Цахим үгийн сан</p>	<p>Зурагт картад буй үгсийг зөв дуудан хэлж буй, зураг дүрс нь зэрэг харагдах бичлэг</p>	<p>Сурагч дагаж унших боломжтой Зогсоцтой дуудаж уншсан бичлэг байна.</p>	<p>Анги бүрд 1 багц</p>

		Зураг ба хэлж буй үгийг зөв тохируулах даалгавартай бичлэг		
3	Бичмэл үсгийг бичих аргыг харуулсан цахим бичлэг, контент	Цагаан толгойн үсгийн зурлагыг зөв дарааллаар бичиж байгааг харуулсан интерактив бичлэг.	Дуу, дүрсний шаардлага стандарт хангасан байна. Бичлэг бүтэн харагдах, үзэгний барилт, бичих дараалал тодорхой харагдахаар байна.	Анги бүрд 1 багц
4	Бусдын яриа, асуулт заавар бүхий бичлэгүүд	Анхааралтай сонсохуйц богино яриа Тодорхой сэдвүүдийн хүрээнд блумын асуултууд гэх мэт	Дуу, дүрсний шаардлага стандарт хангасан байна.	Анги бүрд 1 багц

Хүснэгт 5. Монгол хэл (III анги)-ний сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, шаардлага, тоо хэмжээ

№	Хэрэглэгдэх үүний нэр	Хэрэглэгдэхүүний агуулга	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага /хэмжээ, холбогдох стандарт, бусад/	Тоо хэмжээ
Зурагт үзүүлэн				
1	Зөв бичих дүрсний үзүүлэн	Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх дүрэм Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх дүрэм Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих дүрэм Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих дүрэм	Тухайн ангид судлах дүрсний тодорхойлолт, дүрсний зүй тогтлыг харуулсан бүдүүвч үзүүлэн байна. Тод, зөв бичигдсэн, А-2 хэмжээнээс багагүй байна.	Анги бүрд 1 багц
2	Зөв бичих дадлагын үзүүлэн	Дүрсний дагуу бичсэн бүлэг үгс, холбоо үгийн жагсаалт	Тод, зөв бичигдсэн, А-2 хэмжээнээс багагүй байна.	Сурагч бүрд 1 багц
Хэвлэмэл бүтээгдэхүүн				
	Ардын аман зохиолын эхийн сан	Үндэсний түүх, соёл, уламжлал, үнэт зүйлийг тусгасан зэрэг нийтлэгийн шаардлагыг хангасан байх. Агуулга нь ойлгох, тайлбарлах, ялгах,	-Үлгэр нь бичлэг найруулгатай, зарим хэлц үгийн сонголттой, 200-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй, энгийн болон нийлмэл бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн эх. Зарим	Анги бүрд 1 багц

1		<p>төсөөлөх, таамаглах чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна.</p> <p>Ардын аман зохиолын эхийн сан</p> <ul style="list-style-type: none"> -Онъсоготаавар -Бэлгэ дэмбэрлийн үг -Зугаа үг -Ертөнцийн гурав -Зүйр цэцэн үг -Хэлц үг -Хэл зүгшрүүлэх үг -Түргэн хэллэг -Жороо үг -Шүлэг -Магтаал -Ерөөл -Монгол ардын үлгэр, домог -Дэлхийн сонгодог үлгэр, -Ёгт үлгэр 	<p>зохиол нь хэлц үгийн сонголттой байна.</p> <p>Шүлэг, магтаал 40-өөс доошгүй мөр шүлгээс бүтсэн байна.</p> <p>Хэл зүгшрүүлэх үг нь зөв бичгийн дүрэм бүхий үгийн сантай, 4-аас доошгүй мөр бүхий байна.</p> <p>Юмсын гадаад шинжийг тоочсон, монгол ахуйн сэтгэлгээний үг хэллэгтэй байна.</p>	Сурагч бүрд 1 багц
2	Уран зохиолын эхийн сан	Энгийн болон нийлмэл өгүүлбэрээс бүтсэн үлгэр, өгүүллэг зэрэг эхүүд байна.	Энгийн болон нийлмэл бүтэцтэй өгүүлбэрээс бүтсэн 200-аас доошгүй танил болон танил биш үгийн нөөцтэй эхүүд байна. А5 хэмжээнээс багагүй үсгийн хэмжээ 12 поинтоос хэтрэхгүй байна.	Сурагч бүрд 1 багц
3	Уран зохиолын бус эхийн сан	Захидал (талархсан, бахархсан, бусдын үзэл бодлыг дэмжсэн) Номын тэмдэглэл Мөрөөдөл, Төлөвлөгөө Шошгоны загвар Зааварчилгаа	Бичвэрүүд нь үгийн алдаагүй, найруулга зөв, өгүүлбэр дэх үгийн тоо зохистой, А5 хэмжээнээс багагүй үсгийн хэмжээ 12 поинтоос хэтрэхгүй байна.	Сурагч бүрд 1 багц
4	Дуурайн зохион бичих жишээ загвар бичвэрүүд	Талархсан захидал, төлөвлөгөө, зураг харж дарааллуулан тоочиж бичсэн хоолны жор, үлгэр, номын тэмдэглэл, шүлэг, ертөнцийн гурав зэрэг эхийг дуурайн зохиосон хэд хэдэн хувилбар жишээ эхүүд	Мөр бүр дэх үгийн тоо 4-өөс хэтрэхгүй байхаар дуурайн зохиосон шүлгийн жишээнүүд байна. Сонгосон эхүүд нь сурагчдын танин мэдэхүйд тохирсон, бүтэц нь зөв, найруулга нь ойлгомжтой байна.	Анги бүрд 1 багц
	Үгийн сангийн багц карт	Тухайн ангид судлах зөв бичгийн дүрэмтэй холбоотой бүлэг үгийн нөөц,	3 дугаар ангийн сурагчийн танин мэдэхүй, сэтгэхүйн онцлогт тохирсон хэлц үг байна.	

5		20 хүртэлх хэлц үгийн нөөц, 10 хүртэлх эсрэг утгатай үгийн нөөц, 10 хүртэлх ойролцоо утгатай үгийн нөөц		Сурагч бүрд 1 багц
6	Зөв бичих дүрэмтэй холбоотой үгсийн карт	Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх үгийн нөөц Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх үгийн нөөц Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичихдээ хэрэглэх үгийн нөөц Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичихэд зориулж бичихдээ хэрэглэх үгийн нөөц	Тухайн ангид судлах зөв бичгийн дүрэмтэй холбоотой бүлэг үгийн нөөц байна.	Сурагч бүрд 1 багц

Хүснэгт 7. Монгол хэл (V анги)-ний сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, шаардлага, тоо хэмжээ

№	Хэрэглэгдэхүүний нэр	Хэрэглэгдэхүүний агуулга	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага /хэмжээ, багц үзүүлэнд багтах агуулга, холбогдох стандарт, бусад/	Тоо хэмжээ
Зурагт үзүүлэн				
1	Зөв бичгийн дүрмийн үзүүлэн	Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах дүрэм Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрэм Хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэх дүрэм	Өнгө үзэмжтэй, удаан хэрэглэгдэх баг бөх материалаар хийсэн, хүүхэд бүрт тод харагдахуйц, цэвэр, гаргацтай бичсэн байх, үсгийн хэмжээ тохиромжтой, өлгөхөд зориулсан хэмжээ, даацтай байна.	Ангид 1 багц
2	Зөв бичих дадлагын үзүүлэн	Дүрмийн дагуу бичсэн бүлэг үгс, холбоо үгийн жагсаалт	Тод, зөв бичигдсэн, А-2 хэмжээнээс багагүй байна.	Сурагч бүрд 1 багц
Хэвлэмэл үзүүлэн				
1	Бүдүүвч схем, зураглал	Ятгаж бичсэн зар сурталчилгааны бүтэц дарааллыг харуулсан зураглал, бусдын үзэл бодлыг дэмжсэн эсвэл дэмжээгүй бичсэн	Эхийн бүтэц дараалал нь тодорхой, тод харагдахуйц, онолын эш үндсийг зөв баримталсан, өнгөөр	

		захидлын ялгааг харуулсан бүдүүвч зураглал, жүжигт харилцан яриа нэмснийг зурагласан схем, сэтгэгдэл, мэдрэмжээ бичсэн өдрийн тэмдэглэлийн бүдүүвч бичиглэл зэрэг байна	ялгасан, цэвэр, гаргацтай бичсэн байх, үсгийн хэмжээ тохиромжтой, өлгөхөд зориулсан хэмжээ, даацтай байна.	Анги бүрд 1 багц
2	Ардын аман зохиолын эхийн сан	Танил үгийн хүрээтэй, хүний эерэг зан чанар, ажил хөдөлмөрт дуртай байх, монгол ахуйг тусгасан гэх мэт өргөн утга агуулгатай зүйр цэцэн үг Од гараг эрхэс, амьтан ургамал, байгалийн үзэгдэл, хүний бүтээсэн зүйл гэх мэтийг өнгө, тоо, дүрс, онцлог шинжээр нь таалгах гэж буй зүйлийнхээ адил төстэй шинжийг адилтган далд байдлаар дүрсэлсэн оньсогууд байна. -Онъсого, таавар -Бэлгэ дэмбэрлийн үг -Зугаа үг -Ертөнцийн гурав -Зүйр цэцэн үг -Хэлц үг -Хэл зүгшрүүлэх үг -Түргэн хэллэг -Жороо үг -Шүлэг -Магтаал -Ерөөл -Монгол ардын үлгэр, домог -Дэлхийн сонгодог үлгэр, -Ёгт үлгэр	Эхлэл, гол, төгсгөл гэсэн эхийн бүтэцтэй, 300-аас доошгүй үгтэй, найруулгын хувьд алдаагүй эх байна. -Агуулга нь ойлгох, тайлбарлах, ялгах, харьцуулах, дүгнэх, төсөөлөх, таамаглах чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна -Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон 2 мөртөөс бүтсэн зүйр цэцэн үг байна. - Уран сэтгэмжтэй, хэтрүүлсэн, хүншүүлсэн дүрслэл бүхий бичлэгтэй, монгол ардын үлгэр, дэлхийн сонгодог үлгэрүүд байна.	Сурагч бүрд 1 багц
3	Уран зохиолын эхийн сан	Монгол хэлц үгийн сонголттой, монгол ахуй, амьдрал, монгол хүний сэтгэлгээг харуулсан утгатай, өөрийнхөө зан чанарыг эргэцүүлэхэд чиглэгдсэн, хүмүүжлийн ач холбогдолтой эх зохиол, монголын болон дэлхийн хүүхдийн сонгодог өгүүллэг, үлгэр зэрэг эхүүд байна.	Агуулга нь ойлгох, тайлбарлах, ялгах, харьцуулах, төсөөлөх, таамаглах, дүгнэх чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна. -Хэтрүүлсэн, болон дүрслэл бүхий бичлэгтэй, 300-аас доошгүй үгтэй, эхийн бүтэцтэй, гол хэсэг нь 2-3 цогцолбороос	Сурагч бүрд 1 багц

		Зохиолчийн санаа тодорхой илэрсэн, шүлэг, яруу найраг Үйл явдлын орчныг дүрсэлсэн, баатруудын харилцан яриатай, хашилт, хаалт цэг тэмдгийг түгээмэл хэрэглэсэн жүжгийн зохиолын хэсэг байна.	бүтсэн, үйл явдлын орчныг дүрсэлсэн байна. Хийсвэр, хүнд үг хэллэггүй, голдуу толгой холбосон холбоцтой шүлэг байна.	
4	Уран зохиолын бус эхийн сан	-Утгыг харьцуулж уншихад зориулсан нэг ижил сэдэвтэй атлаа бичлэг, хэлбэр, хэмжээ нь өөр, танин мэдэхүйн агуулгатай шинжлэх ухааны хялбаршуулсан эх -Үйл явдлыг илэрхийлсэн зураг, оролцсон хүмүүсийн нэр, тоо баримт, газар орны нэр, хугацаа зэрэг баримтаас бүтсэн, ойлгомжтой найруулгатай, бүтцийн дагуу бичсэн мэдээ -Бүтцийн дагуу бичсэн, нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлууд буюу ямар нэгэн зүйлийн талаар дэмжсэн эсвэл дэмжээгүй утгыг илэрхийлсэн хэд хэдэн захидал -Баталсан, нотолсон өнгө аяс бүхий бичлэгтэй, зураг, график зэрэг баримт хэрэглэн бичсэн илтгэл -Бусдын анхаарлыг татгал сонирхолтой бичсэн үг хэллэгтэй, сурталчилгааны зураг бүхий зар сурталчилгааны эх -Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж, өөртөө тохиолдсон явдлыг өгүүлсэн, сонирхолтой, хүүхдэд эерэг нөлөөлөлтэй, өдрийн тэмдэглэл	Утгын хувьд ойлгомжтой, зөв найруулгатай, эхийн бүтцийн дагуу, утгын уялдаа холбоотой бичсэн эх Эхийн эхлэл, гол, төгсгөл гэсэн бүтэцтэй, гол хэсэг нь 2-3 цогцолбороос бүтсэн, 300-аас доошгүй үгтэй эх байна.	Сурагч бүрд 1 багц
5	Жишээ загвар бичвэрүүд	Уншсан зохиолынхоо үйл явдлын дарааллыг алдагдуулаагүй, гол гол санааг хураангуйлж, нэгтгэн дүгнэн бичсэн загвар бичвэр байна.	Утгын хувьд ойлгомжтой, зөв найруулгатай бичвэр байна.	Анги бүрд 1 багц
	Зөв бичих дүрэмтэй	Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй	Зөв бичих дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх, чадварыг	

6	холбоотой үгсийн карт	тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах үгсийн нөөц Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийг мэдэж, зөв бичих үгсийн нөөц	сайжруулахад чиглэгдсэн байна.	Сурагч бүрд 1 багц
7	Үгийн сангийн багц карт	Орчин буюу орон байр, газар нутаг, зүг чиг, цаг хугацаа, улирлыг харуулсан, хэзээ, хаана, хаашаа, ямар газар, ямар улирал гэх мэт асуултад хариулагдах танил болон танил бус үг байх. Орчныг дэлгэрүүлэхдээ "ямар" гэсэн асуултад хариулагдах өнгө зүс, тоо хэмжээ, хэлбэр дүрс, овор хэмжээ, шинж байдлыг заасан тэмдэг нэр байх, тэмдэг нэрийн давуу болон харьцуулсан зэргийг хэрэглэсэн жишээ үгс байх, тухайлбал цаснаас цагаан царайтай, хамгийн өндөр охин гэх мэт	Эх, өгүүлбэр зохион найруулан бичихэд зориулагдсан сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, монгол ахуй, сэтгэлгээ, соёлын онцлогийг тусгасан зав бичигдсэн байна.	Сурагч бүрд 1 багц
Цомог				
1	Уран зураг, фото зураг	Орон байр, цаг хугацаа, цаг улирлын байдал зэрэг орчныг тодорхой дүрсэлсэн уран болон фото зураг Онъсогод дүрслэгдсэн эд зүйл, орчин, цаг хугацаа, амьтан, хүний төрх байдал зэргийн шинж байдлыг өөр нэгэн зүйлийн шинж байдалтай адилтгасан утгыг харуулсан зураг. Уран сэтгэмжийг хөгжүүлэх бодит амьдралд байдаггүй зохиомол эд юмс, байгалийн үзэгдэл, хүний бүтээсэн зүйлийг дүрсэлсэн утгатай зураг Сайн сайхан зүйлд уриалж, ятгаж бичих зорилгоор сургуулийн болон нийгмийн орчинд үзэгддэг муу үйл, муу үйлдлийг харуулсан зураг	Өнгө үзэмжтэй, өнгөний ялгаралтай, тусгал нягтрал сайтай байхаас гадна эх сурвалж болон фото зургийг авсан хүний нэр дурдагдсан байна. Хүүхэд бүрд тод харагдахуйц байна. Харилцан яриа, зан авир, төрх байдлыг хөдөлгөөн, харц, дохио зангаагаар бодитой харуулсан зурмал зураг байна. Оюуны өмчийн зөрчилгүй байна.	Анги бүрд 1 багц